



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

МОНГОЛ УЛСЫН СТАТИСТИКИЙН АГУУН

СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2019/04



Мэдээллийн нэгдсэн лавлах: WWW.1212.MN



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙГЭМ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

4 сар
2019

Сүхбаатар сум



ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл.....	3
АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР	4
1. ХҮН АМ, НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ	15
1.2 ЭРҮҮЛ МЭНД	20
1.3 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ	22
1.4 ГЭМТ ХЭРЭГ	25
1.5 ХИЛЭЭР ОРСОН, ГАРСАН ИРГЭД.....	26
2. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	27
2.1 МӨНГӨ, ЗЭЭЛ	27
2.2 АЙМГИЙН НЭГДСЭН ТӨСӨВ	29
2.3 ГАДААД ХУДАЛДАА	31
2.4 ҮНЭ	31
3. ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ	34
3.1 ХӨДӨӨ АЖ АХУЙ	34
3.2 АЖ ҮЙЛДВЭР.....	40
4. БУСАД.....	43



Ерөнхий тэмдэглэл

- I. Товчилсон тэмдэглэлгээ:
- ГХ- Гэмт хэрэг
 - ХАА- Хөдөө аж ахуй
 - АҮ - Аж үйлдвэр
 - ЖДҮ- Жижиг дунд үйлдвэрлэл
 - СЭ - Сэлэнгэ
- II. Саруудыг ромбо тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)
- III. Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XI зэргээр илэрхийлэв
- IV. Дараах тэмдэглэлийг ашиглав:
- ... Мэдээлэл байхгүй
 - X Бүтцийн өөрчлөлт
 - 0.0 Маш бага тоо
 - +, - Зөрүү
 - Гүйцэтгэл байхгүй
 - * Дахин
- "Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.
- V. "Төл" нь төлөвлөгөө, "Гүйц" нь гүйцэтгэл
- VI. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100.0 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

Төсөв: Аймгийн төсвийн орлого зарлага нь төвлөрсөн төсвийн болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ.

Зээл: Гэрээний дагуу олгосон мөнгөн хөрөнгийн төлбөрийг үүрэг гүйцэтгэгчээс шаардах эрх үүсгэж байгаа санхүүгийн хөрөнгийг

Ажилгүйчүүд: Ажилгүйчүүдийн тоонд олон улсын стандарт ангиллын дагуу Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүс орно.

Үнэ: Аймгийн төвийн захад борлогдож байгаа болон хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийг харуулна.

Хэрэглээний үнийн индекс: Өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.

Гэмт хэрэг: Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүй алах хэргийг, хүүхэд гэр бүл нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулав.

Хээлтэгч мал: Нас гүйцсэн эм малыг хамруулна.

Зүй бусаар хорогдсон малын тоонд: Халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга, цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, худаг, хавцалд унах зэрэг хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

Аж үйлдвэр: Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хэмжээ юм. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний өсөлтийг тооцоход нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2016 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.



Сэлэнгэ аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2019 оны эхний 4 сарын байдлаар)


1. НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ



1.1 Хүн ам

2019 оны эхний 4 сарын байдлаар манай аймагт бусад аймаг хотоос бүгд 1138 хүн шилжин ирсэн нь өмнөх оны мөн үеэс 17.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт шилжин ирэгсдийн 50.2 хувь нь эрэгтэйчүүд, 49.8 хувь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэйчүүд 24.4 хувиар, эмэгтэйчүүд 10.7 хувиар өссөн байна.

Шилжин ирсэн иргэдийн тоо




1.2 Эрүүл мэнд

Эхний 4 сарын байдлаар аймгийн хэмжээгээр нийт 610 эх төрж, 615 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс төрөлт 10.5 хувиар өссөн байна. Төрөлтийг насны бүтцээр нь харахад 25-29 насны 193 буюу 31.6 хувь, 20-24 насны 138 буюу 22.6 хувь, 30-34 насны 156 буюу 25.7 хувь, 35-39 насны 83 буюу 13.6 хувь, 40-44 насны 8 буюу 1.3 хувь, 20 хүртэлх насны 32 буюу 5.2 хувийг тус тус эзэлж байна.

Нас барсан хүний тоо 163 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 7 хүнээр буюу 4.1 хувиар буурсан байна. 0-1 насны хүртэлх хүүхдийн эндэгдэл 3, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 2 тохиолдол тус тус бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 54.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Нийт нас баралтын шалтгааны 12.2 хувь нь осол гэмтлийн, 21.3 хувь нь хорт хавдрын өвчний шалтгаантай байна.

Төрсөн эх, амьд төрсөн хүүхэд





Халдварт өвчнөөр 239 хүн өвчилж бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 35.1 хувиар буурсан байна. Нийт халдварт өвчний 60.7 хувийг бэлгийн замын халдварт өвчин, 25.5 хувийг сүрьеэ, 13.8 хувийг бусад халдварт өвчин эзэлж байна.

2019 оны эхний 4 сард нийт 133461 үзлэг хийсний 24.1 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 8.3 хувь нь гэрийн идэвхитэй үзлэг, 13.2 хувь нь диспансерийн хяналтын үзлэг эзэлж, нийт 11963 дуудлаганд үйлчилсний 13.1 хувийг алсын дуудлагаар үйлчилж яралтай тусламж үзүүлсэн.




1.3 Хөдөлмөр

2019 оны эхний 4 сарын байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 820 болсон нь өмнөх оны мөн үеэс 49.6 хувиар өссөн байна. Нийт ажилгүйчүүдийн 52.9 хувийг ерөнхий боловсролтой, 22.4 хувийг дээд боловсролтой, 19.5 хувийг мэргэжилтэй ажилчид, 4.3 хувийг тусгай дунд боловсролтой, 0.9 хувийг боловсролгүй хүмүүс эзлэх боллоо. Шинэ ажлын байранд 97 ажилд зуучлагдсаны 15 иргэн уул уурхайн салбарт, 15 иргэн төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагааны салбарт, 15 иргэн худалдаа, гэр ахуйн засвар, үйлчилгээний салбарт, 14 иргэн ХАА, ан агнуур, ОАА, загас агнуурын салбарт, 11 иргэн зочид буудал, зоогийн газрын салбарт, 10 иргэн боловсруулах үйлдвэрт, 6 иргэн боловсролын салбарт, 11 иргэн бусад салбарт ажилд орсон байна.

Энэ сард бүртгэлтэй ажилгүйчүүдээс 36 хүн ажилд зуучлагдан орж, 122 хүн идэвхгүйн улмаас хасагдаж, 218 хүн шинээр бүртгэгдсэн байна.


Бүртгэлтэй ажилгүйчүүд боловсролоор



1.4 Нийгмийн даатгал, халамж

2019 оны эхний 4 сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 16 688 тэтгэвэр авагчдад 22 962.5 сая төгрөгийг тэтгэвэрт, Тэтгэмжийн даатгалын сангаас 2 651 хүнд 1 005.0 сая төгрөгийг ХЧТА, ЖА, оршуулга, ҮОМШӨ-ны даатгалын сангаас ҮО тэтгэвэр, ХЧТА-ны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 246 хүнд 746.8 сая төгрөг, Ажилгүйдлийн даатгалын сангаас 181 хүнд 250.5 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгожээ.


Нийгмийн халамжийн сангаас 34 100 хүнд 5 350.4 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг олгожээ.

**Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, сая.төг****1.5 Гэмт хэрэг**

2019 оны эхний 4 сарын байдлаар нийт 282 гэмт хэрэг бүртгэгдсэн урьд оны мөн үеэс 13.3 хувиар өссөн байна. Нийт гэмт хэргийн 18.4 хувь нь согтуугаар үйлдэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 17.4 хувиар буурсан байна.

Иргэн болон байгууллагад нийт 784.4 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеэс 444.2 сая төгрөгөөр өссөн байна. Учирсан хохирлоос 205.0 сая төгрөгийг нөхөн төлүүлж, нөхөн төлөлт 26.1 хувьтай байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 36.2 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 33.3 хувийг хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 12.4 хувийг байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, 6.7 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 11.4 хувийг бусад төрлийн гэмт хэрэг эзэлж байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 20.4 хувийг малын хулгай эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр, эзлэх хувь




1.6 Хилээр орсон, гарсан иргэд

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг болон Сүхбаатар боомтоор давхардсан тоогоор 204 911 зорчигч нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеээс 5.8 хувиар өссөн байна. Нийт зорчигчдын 83.3 хувь нь Монгол иргэд, 16.7 хувь нь гадаад иргэд байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хилээр нэвтэрсэн Монгол иргэдийн тоо 6.8 хувиар, гадаад иргэдийн тоо 1.6 хувиар өссөн үзүүлэлтэй байна.

Монгол-Оросын хилийг хялбарчилсан журмаар хил нэвтрэх эрхийн үнэмлэхээр 10 783 хүн зорчсон байна.

Хилээр орсон гарсан иргэд




2. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



2.1 Мөнгө, банк

Монгол банкны мэдээгээр кассын цэвэр орлого 50 888.7 сая төгрөг, цэвэр зарлага 46 907.8 сая төгрөгт хүрчээ. Зээлийн өрийн үлдэгдэл 319 444.2 сая төгрөг байгаа ба үүний 2.6 хувийг чанаргүй зээл эзэлж байна. Иргэдийн мөнгөн хадгаламж 97 675.2 сая төгрөг байна.

Зээлийн өрийн үлдэгдэл /тэрбум.төг/






2.2 Төрийн сан

2019 оны 4 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 6 996.2 сая төгрөг буюу 131.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнээс аймгийн төсвийн орлого 5 082.3 сая төгрөг буюу 124.9 хувийн гүйцэтгэлтэй, сумдын төсвийн орлого 1 754.0 сая төгрөг буюу 93.0 хувийн гүйцэтгэлтэй байна. 2019 оны 04 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн зарлага 22 952.8 сая төгрөг буюу 76.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнээс орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлага 6 852.1 сая төгрөг буюу 58.4 хувь, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлага 16 100.7 сая төгрөг буюу 87.6 хувийн гүйцэтгэлтэй байна. Сумдад 5 011.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 11 232.9 сая төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг, 47.1 сая төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг тус тус шилжүүлсэн байна. Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гүйцэтгэл 148.9 сая төгрөг буюу 100.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.


Орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /сая.төг/



2.3 Гадаад худалдаа

Сэлэнгэ аймагт 2019 оны эхний 4 сарын байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлт 83.6 сая ам доллар, үүнээс экспорт 1.7 сая ам доллар, импорт 81.9 сая ам доллар байна.

Гадаад худалдааны бараа эргэлт, сая.\$






2.4 Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2019 оны эхний 4 сард өмнөх сараас 1.6 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 4.1 хувиар өслөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 4.1 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундаа 9.6 хувь, эм, тариа эмнэлгийн үйлчилгээ 4.1 хувь, тээвэр 3.2 хувь, орон сууц ус цахилгаан хийн болон бусад түлш 2.5 хувь, гэр ахуйн тавилга гэр ахуйн бараа 2.4 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ 1.2 хувь, согтууруулах ундаа тамхи мансууруулах бодис 1.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 1.6 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундаа 3.9 хувь, тээвэр 0.6 хувь, хувцас бөс бараа, гутал 0.3 хувь, орон сууц ус цахилгаан хийн болон бусад түлш 0.2 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа 0.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны 12 дугаар сар = 100%), хувь



Малын үнэ 2018 оны мөн үеэс малын хувьд 50.000-950.000 төгрөгөөр өссөн байна. Түүхий эдийн үнийн хувьд адууны шир 5.000 төгрөг буюу 50.0 хувиар, үхрийн шир 15.000 төгрөг буюу 75.0 хувиар, хонины нэхий 1.500 төгрөг буюу 3 дахин тус тус буурсан байна.

3. ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ




3.1 Хөдөө аж ахуй

2019 оны эхний 4 сарын байдлаар 486.3 мянган эх мал төллөсөн нь урьд оны мөн үеэс 45.7 мянган толгой буюу 10.3 хувиар нэмэгдсэн байна. Мал төллөлтийн хувь Ерөө, Орхонтуул, Жавхлант, Түшиг сумдад өндөр буюу 76.5-88.1 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд 483.1 мянган толгой төл бойжиж байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулахад 46.1 мянган толгой буюу 10.5 хувиар их байна.



2018 оны эхний 4 сарын байдлаар оны эхний нийт малын 0.12 хувьтай тэнцэх 1 750 толгой мал хорогдсон нь урьд онтой харьцуулахад 4.7 дахин бага байна. Хорогдсон нийт малын 1.7 хувь нь өвчнөөр хорогдсон, 34.9 хувь нь хээлтэгч малын хорогдол байна. Хорогдсон нийт малын 994 толгой буюу 56.8 хувь нь Мандал, Баруунбүрэн, Цагааннуур сумдад ногдож байна.




3.2 Аж үйлдвэр

2019 оны эхний 4 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 105.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 146.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь урьд оны мөн үеэс үйлдвэрлэлт 49.8 хувиар, борлуулалт 33.5 хувиар өссөн байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 52.4 хувь нь уул уурхайн салбарт, 31.7 хувь нь хүнсний салбарт 11.1 хувь нь барилгын материалын салбарт, 4.8 хувь нь бусад салбарт бүтээгджээ. Сумдын жижиг, дунд үйлдвэрүүд аймгийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 0.2 хувьтай тэнцэх 221.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 250.3 сая.төгрөгийн борлуулалт хийжээ.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт (тэрбум төг)





4. БАЙГАЛЬ ОРЧНЫ СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ



4.1 Цаг уур орчны мэдээ

ТАНЫ АНХААРАЛД

Цаг агаарын сарын урьдчилсан мэдээнд тухайн сард агаарын дундаж температур болон орох хур тунадасны хэмжээ нь олон жилийн дундажтай харьцуулахад ямар байхыг баруун (Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Говь-Алтай, Баянхонгор), төв (Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Төв, Орхон, Дархан-Уул), зүүн (Хэнтий, Дорнод, Сүхбаатар), говийн (Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говь-Сүмбэр) нутгийн гэсэн **4 бүс** нутаг тус бүрээр ялган зааж өгдөг. Түүнчлэн хэдий үед нутгийн аль хэсэгт дулаарах, хүйтрэх, бороо, цас орох, салхи шуурга болохыг тусгана. Цаг агаарын үзэгдэл нутгийн **30 хувиас** хэтрэхгүйгээр зурвас газраар ажиглагдах тохиолдолд “зарим газраар”, **30-70 хувьд** “ихэнх нутгаар”, **70 хувиас дээш** нутгийг хамрах тохиолдолд “бүх нутгаар” гэсэн нэр томъёо хэрэглэдэг. Дулааны улиралд агаарт болон хөрсний гадарга дээр температур **00**-аас бага болж хүйтрэхийг “цочир хүйтрэл” гэнэ.

Цаг агаарын урьдчилсан мэдээг өдөр бүр 12 цагаар болон нэг, тав хоногоор нарийвчлан гаргаж радио, телевиз, хэвлэлээр нийтэд мэдээлдэг. Цаг агаарын байдал эрс өөрчлөгдөн цаашид хөдөө аж ахуйн болон эдийн засгийн бусад салбарын хэвийн үйл ажиллагаанд саад хийхээр аюултай үзэгдлийн хэмжээнд хүрч болзошгүй тохиолдолд “Урьдчилан анхааруулах мэдээ”, “Урьдчилан сэрэмжлүүлэх мэдээ” гаргаж радио, телевизээр нийт ард иргэдэд, харин ноцтой бэрхшээл учруулж эд хөрөнгө, иргэдийн амь нас хохирохоор онц аюултай үзэгдлийн хэмжээнд хүрэхээр бол “Гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ” гаргаж “Харанга” дохиотойгоор мэдээлэх ба мэдээллийг онцгой байдлын шугамаар нийт ард иргэд, төр засгийн бүх шатны удирдлагад яаралтай хүргэдэг. Засаг дарга нар “Гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ”-г хүлээн авмагц мэдээллийг өөрийн харъяа нутаг дэвсгэрийн иргэдэд хүргэх, гамшгаас хамгаалах, гамшгийн голомтод ажиллах, сэргээн босгох үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах үүрэгтэй.

Ус, цаг агаарын гамшигт үзэгдлийн улмаас хүний амь нас эрсдсэн, байгаль орчин, эд хөрөнгөнд хохирол учирсан тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга ажлын хэсэг томилон ажиллуулж, уг гамшигт үзэгдлээс хамгаалах талаар зохион байгуулсан арга хэмжээ, үр дүн, учирсан хохирол, гарсан зардлын талаархи мэдээллийг нэгтгэн аймаг, нийслэлийн Засаг дарга, Онцгой байдлын газар, хэлтэс, Улсын онцгой байдлын ерөнхий газарт, аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв Ус цаг уурын хүрээлэнд 3 хоногийн дотор тус тус ирүүлнэ. Цаг агаарын мэдээний талаар лавлах, эсвэл байгаль цаг уурын сонин хачин үзэгдлийн талаархи мэдээллийг Улаанбаатар хотын 326606, **326609** утсаар өгөх юмуу “УБ-46, Жуулчны гудамж-5, Ус цаг уурын хүрээлэнгийн “Урьдчилан мэдээлэх сектор” гэсэн хаягаар ирүүлнэ.

Уур амьсгалын тойм *Climate review*

1981-2010 оны дунджаар тавдугаар сард агаарын температурын дундаж нь бүх сумдын нутгаар 11-14 градус дулаан байдаг. Гэвч энэ нь жил бүр харилцан адилгүй байдаг. Тухайлбал: Сүүлийн жилүүдийн байдлаар 1992, 2000, 2007, 2009, 2017 онд олон жилийн



дунджаас 1.0-2.5 градусаар дулаан байж, Орхон-Сэлэнгийн хөндийгөөр өдөртөө 32-37 градус хүрч халж байсан бол 1995, 2011, 2016 онд ихэнх сумдын нутгаар 2-3 градусаар хүйтэн байв.

Хур тунадас нь бүх сумдын нутгаар 14-25 мм хүртэл хур тунадас ордог. Гэвч сүүлийн жилүүдийн байдлаар 1996, 1998, 2004, 2009, 2017 онд харьцангуй бага хур тунадас орж, хуурай халуун байснаас ой хээрийн түймэр ихтэй байв. Харин 1988, 1999, 2002, 2003, 2005, 2010, 2011, 2014, 2016 онд ихэнх нутгаар олон жилийн дунджаас 1-3 дахин их хур тунадас орсон байна.

Тавдугаар сард салхины хурд 15 м/с-ээс дээш ширүүсч шороон шуурга шуурах тохиолдол олон жилийн дунджаар 5-7 удаа ажиглагдаж, хүчтэй шороон болон цасан шуурга шуурч иргэд, аж ахуйн байгууллагуудад ихээхэн хэмжээний хохирол учруулж байжээ.

ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Weather forecast

Агаарын температурын сарын дундаж нь 11-14 градус дулаан буюу олон жилийн дунджийн орчим байх төлөвтэй(1 дүгээр зураг).

Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр сэрүүсч уулархаг нутгаар шөнөдөө 2-7 градус хүйтэн, өдөртөө 6-11 градус дулаан, бусад сумдын нутгаар шөнөдөө 4 градус хүйтнээс 1 градус дулаан, өдөртөө 9-14 градус дулаан байна. Гуравдугаар арав хоногийн дунд үе болон эцсээр нутгийн хойд хэсгээр сэрүүсч шөнөдөө 2 градус хүйтнээс 3 градус дулаан, өдөртөө 11-16 градус дулаан байх төлөвтэй. Гуравдугаар арав хоногийн эхээр Орхон, Сэлэнгийн хөндийгөөр шөнөдөө 8-13 градус, өдөртөө 24-29 градус дулаан, бусад сумдын нутгаар шөнөдөө 5-10 градус, өдөртөө 19-24 градус хүрч дулаарна. Бусад хугацаанд ихэнх сумдын шөнөдөө 4-9 градус, өдөртөө 17-22 градус дулаан байх төлөвтэй.


Энэ сард бүх сумдын нутгаар ОЖД-с бага зэрэг ахиу хур тунадас орох төлөвтэй (2 дугаар зураг).

Нэг болон хоёрдугаар арав хоногийн дунд болон сүүлчээр зарим сумдын нутгаар хур тунадас, уулархаг нутгаар нойтон цас, гуравдугаар арав хоногийн эхэн ба дунд үе, сүүлчээр ихэнх сумдын нутгаар бороо, уулархаг нутгаар хур тунадас орох төлөвтэй. Дуу цахилгаантай.


Энэ үеүдэд салхи зарим газраар 9-14 м/с, нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёр ба гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр нутгийн ихэнх сумдын нутгаар зарим үед 16-18 м/с хүртэл ширүүсч шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй.



05-р сарын агаарын температурын урьдчилсан мэдээ



05-р сарын хур тунадасны урьдчилсан мэдээ



6. БУСАД

а . Хяналт шалгалт

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2019 оны эхний 4 сарын байдлаар 644 аж ахуйн нэгж байгууллага, 107 иргэнд хяналт, шалгалт хийж, 1 808 зөрчил дутагдал илрүүлж, 429 зөрчил арилгуулсан байна.

б. Онцгой байдлын газрын мэдээ

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 245 объект, 17 айл өрхөд үзлэг шалгалт хийж 955 зөрчил илрүүлэн 206 зөрчил дутагдлыг арилгуулсан байна. 2019 оны эхний 3 сарын байдлаар объектод 59, ой хээрийн 2 гал түймэр гарч 371.7 сая төгрөгийн хохирол учирсан байна.

в. Түүвэр судалгаа

2019 оны эхний 4 сарын байдлаар Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг 136 өрхөөс, Ажиллах хүчний судалгааг 210 өрхөөс авч, судалгаанд хамрагдсан өрхүүдэд урамшуулал болгон 1310.0 мянган төгрөг олгоод байна.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Д.ГҮНДЭГМАА

**ХҮН АМ, НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ****1.1 ХҮН АМ****1.1.1 ШИЛЖИЖ ИРСЭН ИРГЭДИЙН ТОО, сумдаар**

Сумын нэр	2016-IV	2017-IV	2018-IV		2019-IV	
			Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Дүн	863	774	971	512	1138	567
Алтанбулаг	30	37	16	8	16	8
Ерөө	41	60	48	28	59	24
Зүүнбүрэн	26	26	29	20	28	13
Мандал	150	157	380	219	390	192
Орхон	17	14	12	3	14	7
Сант	17	17	32	15	38	16
Цагааннуур	38	21	16	7	50	27
Баянгол	48	59	55	25	68	34
Сайхан	115	71	55	20	159	74
Орхонтуул	26	35	24	16	45	24
Баруунбүрэн	23	21	26	14	46	26
Шаамар	21	47	31	19	44	25
Хүдэр	24	16	20	7	31	14
Сүхбаатар	202	151	179	91	86	53
Жавхлант	31	16	12	5	23	11
Түшиг	29	5	12	4	26	14
Хушаат	25	21	24	11	15	5

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтэс

1.1.2 ТӨРӨЛТ

Сумын нэр	Төрсөн эх				<u>2019 - IY</u> 2018 - IY
	2016 - IY	2017 - IY	2018 - IY	2019 - IY	
Бүгд	611	518	552	610	110.5
Алтанбулаг	1	1	1		
Ерөө	18	5	16	14	87.5
Зүүнбүрэн	3	1	3	1	33.3
Мандал	200	184	193	200	103.6
Орхон					
Сант					
Цагааннуур	1	6	7	4	57.1
Баянгол	1	3	1	1	100.0
Сайхан	42	28	22	30	136.4
Орхонтуул	5	1	4		
Баруунбүрэн	2		2	1	50.0
Шаамар	1	1	2		
Хүдэр		1	1	1	100.0
Сүхбаатар	323	284	294	350	119.0
Жавхлант		1			
Түшиг	11	2	5	8	160.0
Хушаат	3		1		

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.1.3 АМЬД ТӨРСӨН ХҮҮХДИЙН ТОО**


Сумын нэр	амьд төрсөн хүүхэд								<u>2019 - IY</u> <u>2018 - IY</u>
	2016- IY		2017- IY		2018 - IY		2019 - IY		
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	
Бүгд	611	281	518	310	553	261	615	299	111.2
Алтанбулаг	1	1	1	1	1				
Ерөө	18	11	5	4	17	10	15	6	88.2
Зүүнбүрэн	3		1	1	2		1		50.0
Мандал	200	89	185	113	193	96	203	100	105.2
Орхон									
Сант									
Цагааннуур	1		5	3	7	4	4	2	57.1
Баянгол	1		2	2	1		1		100.0
Сайхан	42	24	28	20	22	12	31	17	140.9
Орхонтуул	5	3	1	1	4				
Баруунбүрэн	2	1			2	2	1		50.0
Шаамар	1		1		2	1			
Хүдэр			1	1	1		1		100.0
Сүхбаатар	323	147	285	163	294	132	350	169	119.0
Жавхлант			1	1					
Түшиг	11	5	2		6	4	8	5	133.3
Хушаат	3				1				

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

1.1.5 ТӨРСӨН ЭХ, боловсролоор

Үзүүлэлт	2016 - IY	2017 - IY	2018 - IY	2019 - IY	<u>2019-IY</u> <u>2018-IY</u>
Бүгд	611	518	552	610	110.5
Дээд боловсрол	108	120	132	145	109.8
Мэргэжлийн болон техникийн боловсрол	27	22	25	31	124.0
Дунд боловсрол	429	340	368	395	107.3
Бага боловсрол	35	29	24	26	108.3
Боловсролгүй	12	7	3	13	4.3*

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**Төрсөн эх, боловсролоор****1.1.6 ТӨРСӨН ЭХ, насны бүлгээр**

Үзүүлэлт	2016 -ИҮ	2017 - ИҮ	2018 - ИҮ	2019 - ИҮ	$\frac{2019-ИҮ}{2018-ИҮ}$
Бүгд	611	518	552	610	110.5
20 хүртэлх	43	36	26	32	123.1
20 - 24	160	147	140	138	98.6
25 - 29	194	136	163	193	118.4
30 - 34	109	108	119	156	131.1
35 - 39	85	72	86	83	96.5
40 - 44	20	19	18	8	44.4
45 - 49					

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.1.7 НАС БАРАЛТ**

Сумын нэр	Нас баралт								2019-ИҮ 2018-ИҮ
	2016 - ИҮ		2017 - ИҮ		2018 - ИҮ		2019 - ИҮ		
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	
Бүгд	193	82	154	58	170	57	163	57	95.9
Алтанбулаг	8	5	7	3	10	4	11	3	110.0
Ерөө	15	4	14	4	14	4	12	3	85.7
Зүүнбүрэн	5	2	2	1	4	1	5	1	125.0
Мандал	46	20	45	15	57	21	41	16	71.9
Орхон	3	2	3	2	2		2		
Сант	3	1	4	2			4		
Цагааннуур	7	1	7	1	5	3	5	3	100.0
Баянгол	12	4	5	3	3	1	5		166.7
Сайхан	16	7	12	4	18	7	13	4	72.2
Орхонтуул	6	3	4	3	2		9	3	4.5*
Баруунбүрэн	5	1	4	3	3	2	6	5	2.0*
Шаамар	6	3	4	2	5	2	5	2	100.0
Хүдэр	6	2	2		2		3		150.0
Сүхбаатар	48	21	38	14	39	11	38	16	97.4
Жавхлант	1		1		2		1		50.0
Түшиг	3	3				1			
Хушаат	3	3	2	1			3	1	

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

1.1.8 НЯЛХСЫН ЭНДЭГДЭЛ

Сумын нэр	0-1 насны хүүхэд			
	2016 - ИҮ	2017 - ИҮ	2018 - ИҮ	2019 - ИҮ
Дүн	17	2	10	3
Алтанбулаг				
Ерөө	1			
Зүүнбүрэн			1	
Мандал	3		1	
Орхон				
Сант				
Цагааннуур	1	1		
Баянгол				
Сайхан	1		1	
Орхонтуул				
Баруунбүрэн	1			
Шаамар	1			
Хүдэр				
Сүхбаатар	9	1	7	3
Жавхлант				
Түшиг				
Хушаат				

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



Сумын нэр	1-5 насны хүүхэд			
	2016 - IY	2017 - IY	2018 - IY	2019 - IY
Дүн	3	2	1	2
Алтанбулаг				
Ерөө		1		
Зүүнбүрэн				
Мандал		1		
Орхон				
Сант	1			
Цагааннуур				
Баянгол				
Сайхан				1
Орхонтуул				
Баруунбүрэн				
Шаамар				
Хүдэр				
Сүхбаатар	2		1	1
Жавхлант				
Түшиг				
Хушаат				

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

1.1.9 НАС БАРАЛТ, насы бүлгээр

Үзүүлэлт	2016 - IY	2017 - IY	2018 - IY	2019 - IY	$\frac{2019 - IY}{2018 - IY}$
Бүгд	193	154	170	163	95.9
Эмэгтэй	77	56	73	85	116.4
0 - 1	19	6	10	3	30.0
1 - 5	3	2	1	2	2.0*
6 - 18	6	4		3	
19 - 54	61	45	56	43	76.8
54-с дээш	104	97	103	112	108.7

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

**1.2 ЭРҮҮЛ МЭНД****1.2.1 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГСӨД**

Сумын нэр	Бүх халдварт өвчин				2019 - IY 2018 - IY
	2016 - IY	2017 - IY	2018 - IY	2019 - IY	
Бүгд	1293	214	368	239	64.9
Алтанбулаг	35	10	33	15	45.5
Ерөө	90	5	11	9	81.8
Зүүнбүрэн	20	17	5	4	80.0
Мандал	488	25	49	41	83.7
Орхон	6		10		
Сант	13	1			
Цагааннуур	59	8	17	10	58.8
Баянгол	20	2	28	10	35.7
Сайхан	90	13	31	14	45.2
Орхонтуул	7	4	4	4	100.0
Баруунбүрэн	19		2	2	100.0
Шаамар	34	18	9	9	100.0
Хүдэр	46	1	3		
Сүхбаатар	320	102	147	115	78.2
Жавхлант	21	1	4	1	25.0
Түшиг	6	5	14	3	21.4
Хушаат	19	2	1	2	2.0*

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

Сумын нэр	Бэлгийн замын өвчин				2019 - IY 2018 - IY
	2016 - IY	2017 - IY	2018 - IY	2019 - IY	
ДҮН	155	109	277	145	52.3
Алтанбулаг	7	5	28	3	10.7
Ерөө	6	1	5	3	60.0
Зүүнбүрэн	3	5	5	3	60.0
Мандал	25	10	29	24	82.8
Орхон			9		
Сант		1			
Цагааннуур	5	5	16	7	43.8
Баянгол			22	3	13.6
Сайхан	9	5	27	5	18.5
Орхонтуул	2		2	2	100.0
Баруунбүрэн	8			1	
Шаамар		8	8	8	100.0
Хүдэр	4		2		
Сүхбаатар	79	65	112	82	73.2
Жавхлант	2		1	1	100.0
Түшиг	2	4	11	2	18.2
Хушаат	3			1	

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



Сумын нэр	Гипатит				<u>2019 - IIY</u> <u>2018 - IY</u>
	2016 - IY	2017 - IY	2018 - IY	2019 - IY	
ДҮН	2	0	2	0	0.0
Алтанбулаг			1		
Ерөө					
Зүүнбүрэн					
Мандал	2				
Орхон					
Сант					
Цагааннуур					
Баянгол					
Сайхан					
Орхонтуул					
Баруунбүрэн					
Шаамар					
Хүдэр					
Сүхбаатар					
Жавхлант					
Түшиг					
Хушаат			1		

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар

Сумын нэр	Сүрьеэ				<u>2019 - IY</u> <u>2018 - IY</u>
	2016 - IY	2017 - IY	2018 - IY	2019 - IY	
ДҮН	77	63	66	61	92.4
Алтанбулаг	7	4	3	9	3.0*
Ерөө	2	4	6	6	100.0
Зүүнбүрэн	1			1	
Мандал	17	15	16	12	75.0
Орхон	2		1		
Сант	1				
Цагааннуур	3	3	1	2	2.0*
Баянгол	6	2	6	7	116.7
Сайхан	8	5	4	5	125.0
Орхонтуул	3	4	1	2	2.0*
Баруунбүрэн			2	1	50.0
Шаамар	3		1	1	100.0
Хүдэр	1		1		
Сүхбаатар	23	23	18	13	72.2
Жавхлант			3		
Түшиг		1	3	1	33.3
Хушаат		2		1	

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



1.3 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

1.3.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮД, боловсролоор

Үзүүлэлт	2016 - IV	2017 - IV	2018 - IV	2019 - IV	<u>2019 - IV</u> <u>2018 - IV</u>
Бүгд	970	847	548	820	149.6
Эмэгтэй	433	399	275	392	142.5
Дээд	202	263	155	184	118.7
Тусгай дунд	70	61	39	35	89.7
Ерөнхий боловсролтой	535	388	234	434	185.5
Мэргэжилтэй ажилчид	156	129	114	160	140.4
Боловсролгүй	7	6	6	7	116.7

Эх үүсвэр: Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

1.3.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, сумдаар

Сумын нэр	Сарын эхний ажилгүйчүүд	Тухайн сард хасагдсан		Нэмэгдсэн	Сарын эцэс
		Ажилд зуучлагдсан	Идэвхгүйн улмаас хасагдсан		
ДҮН	760	36	122	218	820
Алтанбулаг	38		8	1	31
Ерөө	66	2	6	14	72
Зүүнбүрэн	5				5
Мандал	114		6	34	142
Орхон	7			1	8
Сант	13	2	4	2	9
Цагааннуур	38	3	6	9	38
Баянгол	81	9	20	33	85
Сайхан	47	1	13	27	60
Орхонтуул	26	4	9	8	21
Баруунбүрэн	0				0
Шаамар	56	1	8	15	62
Хүдэр	15	5		15	25
Сүхбаатар	179		39	50	190
Жавхлант	3				3
Түшиг	66	9		9	66
Хушаат	6		3		3

Эх үүсвэр: Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

**1.3.4 ШИНЭ АЖЛЫН БАЙР**

	Бүгд	ХАА, ан агнуур, ОАА, загас агнуур	Уул уурхай, олборлох үйлдвэр	Боловсруулах үйлдвэр	Цахилгаан, дулаан, усан хангамж	Барилга	Худалдаа, гэр ахуйн засвар, үйлчилгээ	Зочид буудал, зоогийн газар	Тээвэр, холбоо	Санхүүгийн үйл ажиллагаа	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа	Боловсрол	Эрүүл мэнд, нийгмийн халамж	урлаг, үзвэр, үйлчилгээний бусад үйл ажиллагаа
ДҮН	97	14	15	10	0	0	15	11	1	4	0	1	15	6	4	1
Алтанбулаг	3												2		1	
Ерөө	11	1	3	1			1						3	1		1
Зүүнбүрэн	0															
Мандал	15	2					11					1	1			
Орхон	0															
Сант	8	3											3	2		
Цагааннуур	4						1			3						
Баянгол	1		1													
Сайхан	8							5		1				2		
Орхонтуул	3							1					2			
Баруунбүрэн	0															
Шаамар	6			2				2					2			
Хүдэр	7			4				3								
Сүхбаатар	0															
Жавхлант	2												2			
Түшиг	25	8	11	2					1						3	
Хушаат	4			1			2							1		

Эх үүсвэр: Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

**1.3 НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ****1.3.5 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН, мян.төг**

Үйлчилгээний төрөл	Хүн	Мөнгөн дүн, сая.төг
Халамжийн тэтгэвэр	2 407	1 546.1
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	2 916	702.2
Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	22	26.4
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ		
Жирэмсэн эхчүүдэд олгосон мөнгөн тэтгэмж	1 509	137.4
Ахмад дайчин, алдар цолтон ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	66	26.4
Эхийн алдар одонтой эхчүүдэд олгосон тусламж	8 572	1 115.0
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	2 129	147.4
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	378	54.0
Насны хишиг	4 474	351.8
Цалинтай ээж хөтөлбөр	5 458	949.6
Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөр	201	62.6
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	5 968	231.6
Ахмад настны хөнгөлөлт		
Нийт	34 100	5 350.4

Эх үүсвэр: Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

1.3.6 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ОРЛОГО, АВЛАГА, сая.төг, сумдаар

Сумдын нэр	НДШ-ийн орлого			НДШ-ийн авлага		
	төл	гүй	хувь	а/а нэгж	төсөв	бүгд
ДҮН	12 056.3	12 950.1	107.4	7 979.2	214.7	8 193.9
Алтанбулаг	178.1	207.1	116.3	19.0	14.3	33.3
Ерөө	1 290.5	1 470.4	113.9	31.4	4.3	35.7
Зүүнбүрэн	124.5	116.4	93.5	16.4	15.1	31.5
Мандал	3 128.1	3 577.0	114.3	457.3	49.1	506.5
Орхон	145.2	95.0	65.4	5.3	2.2	7.5
Сант	95.0	113.3	119.3	17.2	2.9	20.1
Цагааннуур	391.2	330.7	84.5	247.7		247.7
Баянгол	258.9	273.0	105.4	189.9		189.9
Сайхан	1 897.9	1 310.4	69.0	5 516.9	10.4	5 527.3
Орхонтуул	158.2	194.7	123.1	3.8	1.1	4.9
Баруунбүрэн	150.9	169.4	112.3	67.8	3.7	71.5
Шаамар	204.1	247.8	121.4	1.9	2.9	4.8
Хүдэр	141.0	157.1	111.4	40.7		40.7
Сүхбаатар	3 543.9	4 348.1	122.7	1 305.5	67.0	1 372.5
Жавхланта	108.1	102.4	94.7	40.2	20.8	61.1
Түшиг	111.8	106.5	95.3	18.0		18.0
Хушаат	128.8	130.8	101.6		21.0	21.0
ТИХ						0.0

Эх үүсвэр: Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс

**1.4 ГЭМТ ХЭРЭГ****1.4.5 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО**

Сумын нэр	Гэмт хэргийн тоо				<u>2019 - IV</u> <u>2018 - IV</u>
	2016 - IV	2017 - IV	2018 - IV	2019 - IV	
ДҮН	268	220	249	282	113.3
Алтанбулаг	16	16	11	30	272.7
Ерөө	17	14	14	20	142.9
Зүүнбүрэн	2	2	6	6	100.0
Мандал	80	71	65	86	132.3
Орхон	6	7	4	6	150.0
Сант	14	4	1	1	100.0
Цагааннуур	8	5	14	5	35.7
